



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/312

Номгон

Г Цэцэрлэгүүдийн сургалт эрхлэх тусгай  
зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт  
оруулах тухай


Боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, соёл урлагийн газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 87 тоот албан бичгээр ирүүлсэн саналын дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хавсралтад заасан цэцэрлэгүүдийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хавсралтад заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2.Боловсролын салбарын болон бусад хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэрийг мөрдөж, боловсролын үйлчилгээг чанартай явуулахыг цэцэрлэгийн эрхлэгч нарт, Сургуулийн өмнөх боловсролын төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Боловсрол,соёл урлагийн газар /М.Мөнхбат/-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс / Д.Энхжаргал/-т даалгасугай.

ДАРГА



Г.БАТЖАРГАЛ

1200622

Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/372 дугаар захирамжийн хавсралт



СУРГАЛТ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД  
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн нэмэлт өөрчлөлт
1	2	3	4
1	6 дугаар цэцэрлэг ✓	0001861	Барилгад өргөтгөл хийж үндсэн бүлэг 3 нэмэгдсэн.
2	8 дугаар цэцэрлэг ✓	0001863	Үндсэн бүлэг 1 нэмэгдсэн.
3	10 дугаар цэцэрлэг ✓	0001865	Харьяалал Рашаантын 10 дугаар баг болж өөрчлөгдсөн.
4	Өлзийт ✓	0001869	Бага, дунд ахлах бэлтгэл бүлэг болж бүлгийн багшийн тоо 4, дуу хөгжмийн багш 1 болсон.
5	Жинст ✓	0001870	Үндсэн бүлэг 3, нүүдлийн бүлэг 2 болсон.
6	Богд ✓	0001871	2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөл ашиглалтад орж үндсэн бүлэг -3 нэмэгдсэн.
7	Баянговь ✓	0001872	2019 онд 75 хүүхдийн хүчин чадалтай барилгын өргөтгөл ашиглалтад орж 3 бүлэг шинээр нэмэгдсэн.
8	Баянлиг ✓	0001873	Нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээтэй уялдуулан үндсэн бүлэг 7 болж өөрчлөгдөн нэг бүлэг хасагдсан.
9	Баян-Өндөр ✓	0001876	Үндсэн бүлэг-5, ээлжийн бүлэг 1, бүлгийн багш 5, дуу хөгжийн багш 1, хувилбарт сургалтын багш 1 болсон.
10	Бууцагаан ✓	0001878	Үндсэн бүлэг 7 бүлэг болсон.
11	Бөмбөгөр ✓	0001879	Үндсэн бүлэг 2 нэмэгдсэн.
12	Хүрээмарал ✓	0001880	Барилгын өргөтгөл баригда, үндсэн бүлэг 3 нэмэгдсэн.
13	Эрдэнэцогт ✓	0001886	Нэгдүгээр багийн төв дээр 25 хүүхдийн хүчин чадалтай салбар бүлэг 1 нэмэгдсэн, үндсэн бүлэг 4 болж өөрчлөгдсөн.
14	Гэгээхэн	0001889	2-оос доош насны 2 бүлэг ажиллуулдаг.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_